

0



“ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

**ТРАНСФОРМАТОРЫН ЗАСВАРЫН ЦЕХИЙН САНТЕХНИКИЙН ИЖ БҮРЭН
ЗАСВАР, ШИНЭЧЛЭЛИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендерийн нэр: *Трансформаторын засварын цехийн сантехникийн
иж бүрэн засвар, шинэчлэлийн ажил*

Тендерийн дугаар: **ЦДУС-2019/ХА-15**

**УЛААНБААТАР ХОТ
2019 ОН**

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2019-04-10

“Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Трансформаторын засварын цехийн сантехникийн иж бүрэн засвар, шинэчлэлийн ажил” гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерийг 2019 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 10:00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг Улаанбаатар хот-36 Хан-Уул дүүрэг 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-45 “ЦДУС” ТӨХК-ийн төв байр, 3 дугаар давхар 311 тоотод 2019 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 10:10 цагт тендерийг нээнэ.

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-45, “ЦДУС” ТӨХК-ийн төв байр, 3 дугаар давхар 309 тоот.

**Худалдан авах ажиллагаа, Ханган нийлүүлэлтийн хэлтэс.
Утас: 99248880. Факс:976-70043287**

Нэг. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарыт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарыт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын**
 - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

**хүчинтэй
байх
хугацаа**

- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө уtsan холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Хоёр. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

| ТОӨЗ-НЫХОЛБОДОХ ЗААЛТ | Шалгуур үзүүлэлт |
|------------------------------|---|
| ТОӨЗ 1.1 | <p>1. Үнийн санал маягтын дагуу ирүүлэх</p> <p>2. Улсын бүртгэлийн гэрчилгээ; /нотариатаар баталгаажуулж ирүүлнэ/</p> <p>3. Татварын тодорхойлолт;</p> <p>4. Тус ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөлтэй байх;</p> <p>5. Сүүлийн нэг жилийн буюу 2018 оны санхүүгийн тайлан /аудитын дүгнэлтийн хамт/;</p> <p>6. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаархи мэдээлэл ирүүлнэ. /сүүлийн 1 жил /</p> <p>7. Сүүлийн 1 жилийн ижил төстэй ажил гүйцэтгэсэн талаар /гэрээний хуулбар комиссын актны хуулбар хавсарган ирүүлэх/</p> <p>8. Ажил гүйцэтгэх график;</p> <p>9. Тендерт оролцогч нь санал болгож буй үнийн дүнд багтаан тухайн ажлыг стандартын дагуу чанартай хийж дуусган хүлээлгэн өгөх, чанарын баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.</p> <p>10. Ажлын даалгаварын дагуу гүйцэтгэх ажилд шаардлагатай бараа материалын жагсаалт;</p> <p>11. Компанийн дэлгэрэнгүй танилцуулга;</p> <p>Жич: Дээрх баримт бичгийн аль нэгийг ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно.</p> |
| ТОӨЗ 2.1 | <p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn-д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалыа цахим хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>Огноо: Тендерийг 2019 оны 04 дүгээр сарын 16-ны Цаг: 10 цаг 00 минут.</p> |
| ТОӨЗ 6.2 | <p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаараас бүрдэнэ:</p> <p>“Трансформаторын засварын цехийн сантехникийн иж бүрэн засвар, шинэчлэлийн ажил”</p> <p>ЦДУС-2019/ХА-15</p> |

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**БАТЛАВ
ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР**

Б.ДАШДАВАА



**Трансформаторын засварын цехийн сантехникийн
шинэчлэлтийн ажлын эзэлхүүн**

2019.04.01

- 1. DAKON брэндийн PTE 45 маркийн 2 ширхэг цахилгаан тогоо болон PTE 60 маркийн 1 ширхэг цахилгаан тогоонд урсгал засвар гүйцэтгэх ажил**

| Одоогийн төлөв | Хийгдэх шинэчлэлтийн ажил |
|--|--|
|  | <ul style="list-style-type: none"> • Цахилгаан тогооны халаагуурт урсгал засвар гүйцэтгэх • Сангийн холболтын хэсгүүдийг шинээр хийх • Цахилгаан тогооны халаагуурын бакыг шинээр шилэн хөвөнтэй тугалган цаасаар ороох • Цахилгаан тогооны цахилгааны холболтын хэсгийг галын аюулаас урьдчилан сэргийлэн гал, усны хамгаалалттай розетка суурилуулах • Цахилгаан тогооны удирдлагын хэсэгт үзлэг үйлчилгээ цэвэрлэгээ хийх • Пускателийн үзлэг, үйлчилгээ хийх |

- 2. Цехийн оффис болон засварын заалны баруун, зүүн жигүүрийн системийн эргэлтийн 6 ширхэг насосыг шинэчлэх ажил**

| Одоогийн төлөв | Хийгдэх шинэчлэлтийн ажил |
|---|--|
|  | <ul style="list-style-type: none"> • Эргэлтийн насосыг шинээр солих • Холболтын хэсгийг шинээр солих • 2 талын насосыг автомат удирдлагаар ээлжлэн амарч ажилдаг болгох • Насос зогсоход мэдээлэл өгдөг аваарийн дохиолол шинээр суурилуулах |



шалтгай тулсан сандыгтай сандыг
өндөрлөх

- Сангийн системийн хуучан паарыг шинэчлэх буюу орос паараар солих /багана хооронд 15 секцтэй 2 хэсэг паар суурилуулах/
- Сангийн системийг цагаан саарал өнгөөр будах
- Аваарын клапанг шинэчлэх
- Хог болон зэв шүүгч шүүрийг цэвэрлэх
- Сангийн системд автомат хий авагч байршуулах
- Даралтын баллон байршуулах

4. Оффисийн хэсэгт 1,2,3-р давхарын сангийн системд ургал засвар гүйцэтгэх ажил

| Одоогийн төлөв | Хийгдэх шинэчлэлтийн ажил |
|----------------|---|
| | <ul style="list-style-type: none"> Оффисийн сангийн системийн паарны оролт (өгөх)-ын хаалтуудыг бөмбөлгэн хаалтаар солих /Одоо байгаа хаалтууд тохируулгагүй тул дээд давхарууд их халж 1-р давхарын паар халахгүй байна/ Оффисийн сангийн системийн пааруудыг авч даралттай усаар цэвэрлэн буцааж суурилуулах Оффисийн сангийн системд тохирсон автомат хий авагч суурилуулах |

5. Галын гидрант болон дүш, ахуйн хэрэглээний усны нөөцийн савыг цехийн сангийн системийн усны нөөц савтай нэгтгэх ажил

| Одоогийн төлөв | Хийгдэх шинэчлэлтийн ажил |
|----------------|--|
| | <ul style="list-style-type: none"> Галын гидрантууд, дүш, ахуйн хэрэглээний усны нөөц савыг сангийн системийн усны нөөц савтай нэгтгэн багажны өрөөнд байршуулах Холболтуудыг шинээр монтажлан гүйцэтгэх |

6. 2-р давхарын дүшний өрөөнд 60 литрийн багтаамжтай бойлуур шинээр суурилуулах ажил

| Одоогийн төлөв | Хийгдэх шинэчлэлтийн ажил |
|----------------|--|
| | <ul style="list-style-type: none"> 2-р давхарын сантехникийн холболтыг шинэчлэх 60 литр багтаамжтай шинэ бойлуур суурилуулах |

7. 1, 2-р давхарын ариун цэврийн өрөөнүүдийг хэвийн ажиллагаанд оруулах ажил

| Одоогийн төлөв | Хийгдэх шинэчлэлтийн ажил |
|----------------|---------------------------|
|----------------|---------------------------|



- 1, 2-р давхарын ариун цэврийн өрөөний ус алдалтыг зогсох
- Ариун цэврийн өрөөнөөс гарсан бохирын шугамын бөглөөг гаргах

8. Галын гидрантын шугам хоолойг солих, гидрантын насосыг худагтай өрөөнд байршуулах

Одоогийн төлөв

Хийгдэх шинэчлэлтийн ажил



- Шугам хоолойг солих, шинэчлэх
- Насосыг шилжүүлэн байрлуулах, бэхлэх

9. Бохирын худагт үйлчилгээ хийх ажил

Одоогийн төлөв

Хийгдэх шинэчлэлтийн ажил



- Бохирын худагны бохирыг соруулах, шугам хоолойнд шинэчлэлт хийх
- Худагт шинээр бетонон таг тавих

Жич: Ажлын даалгавартай нарийвчлан танилцахыг хүсвэл БЗД 2-р хороо Туул дэд станцын дэргэдэх “Трансформаторын засварын цех”-д биечлэн үзэж болно.

Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

- Бид, [тэндерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тэндерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
- Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
- Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана. 4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |
| Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ | |
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна. 7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдолын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. |

Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.

9. Зөрчил, гологдол арилгах

9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.

10. Зөрчил, гологдол арилгахгүй байх

9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.

10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

11. Үе шатны ажлын хуваарь

11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.

11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.

12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх

12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.

13. Алданги

13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

| | |
|---|---|
| 14. Ажил дуусгах | 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна. |
| 15. Хүлээж авах | 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна. |
| 16. Эцсийн тооцоо | 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай запруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана. |
| 17. Ашиглалт, засвар, үйлчилгээн ий гарын авлага | 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө. 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана. |
| 18. Гэрээг цуцлах | 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй. 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй: (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоо тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоо тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон; |

- (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
- (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
- (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
- (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр

19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

20. Гүйцэтгэлээс чөлөөлөх

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсоноо. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.1 Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: “**Трансформаторын засварын цехийн сантехникийн иж бүрэн засвар, шинэчлэлийн ажл**”

ЦДУС-2019/ХА-15

ГЕН 2.1 Ажил нь : “**Трансформаторын засварын цехийн сантехникийн иж бүрэн засвар, шинэчлэлийн ажл**”

Ажлын талбай нь : “**ЦДУС” ТӨХК-ийн Туул дэд станц**

ГЕН 3.1 Төслийн менежер нь: ТХХ-ийн ПХБ-ийн төслийн инженер Б.Галбадрах

ГЕН 4.1 Зөвшөөрөл авч ажил эхлэсэн өдрөөр тооцогдоно.

Ажил эхлэх өдөр 2019 оны дугаар сарын

Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр 2019 оны дугаар сарын

ГЕН 7.1 Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш ... хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.

ГЕН 9.1 Чанарын баталгаат хугацаа **12 сар** байна. Баталгаат хугацаанд гарсан гэмтэлийг гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.

Барьцаа хөрөнгө гэрээний нийт үнийн дүнгийн **5 хувь** байх бөгөөд Гэрээ дүгнэж акт үйлдсэнээс өдрөөс хойш 6 сарын дараа барьцаа хөрөнгийг чөлөөлж гүйцэтгэгчид олгоно.

ГЕН 13.1 Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний нийт үнийн **0.05%** байна.

Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний нийт үнийн **5%** байна.

ГЕН 17.1 Гүйцэтгэлийн тайланг гэрээ дүгнэж ажил хүлээлцэхэд гаргаж өгнө.

ГЕН 19.1 Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын **100%-иар** тооцно.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

| | |
|-----------------|-----------------|
| (Тамга, тэмдэг) | (Тамга, тэмдэг) |
| (Гарын үсэг) | (Гарын үсэг) |
| (Албан тушаал) | (Албан тушаал) |

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....
хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20... онд: _____ төгрөг; 20... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан,

цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны _____ дугаар сарын _____-ны өдөр эхэлж, _____ оны _____ дугаар сарын _____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний өрөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний өрөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын
үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын
үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]